

## **"СОЁМБО ДААТГАЛ" ХХК**

1. Даатгалын тухай хуулийн 8.5-д заасан үндэслэлүүд;
2. даатгуулагч даатгалын хураамжийг гэрээнд заасан хугацаанд төлөөгүй тохиолдол;
3. Монгол улсын нутаг дэвсгэрээс гадна учирсан аливаа хохирол;
4. даатгуулахаас өмнө учирсан хохирол, хор нөлөөг арилгах;
5. хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр хохирлын нэхэмжлэлийг даатгалын тохиолдол болсон өдрөөс хойш хуанлийн 90 хоногийн дотор даатгагчид гаргаагүй бол;
6. даатгалын тусгай нөхцөлд заасан үндэслэл;
7. даатгуулагчийн хууль бус, санаатай, гэмт хэргийн шинжтэй үйлдлийн үр дагавар;
8. даатгалын эрсдэлд хамрагдаагүй форс мажорт хамаарах хүчин зүйлийн улмаас учирсан хохирол;
9. дайн болон байлдаан, хувьсгал, булаан эзлэх, барьцаалах, мина, бөмбөг дэлбэрэх, терроризм зэрэг үйл явдлуудын улмаас үүссэн хохирол;
10. нийтийн эмх замбараагүй байдал, иргэний бослого, үймээн, баривчлан саатуулах, самуун бослого, ажил хаялт болон улс төрийн шинж чанартай үйл ажиллагаанаас үүдсэн хохирол;
11. атомын, цөмийн дэлбэрэлт, байлдааны зэвсэг, цацраг идэвхт бодисоос үүдэлтэй хохирол;
12. учирсан хохирлоос үүдэн гарсан эдийн засгийн хохирол, олох ёстой байсан орлого болон бусад үр дагавар;
13. даатгагчтай тохиролцолгүйгээр хохирлын бодит хэмжээг тогтоох, батлах боломжгүй болгосон тохиолдол;
14. нотолгоогүй хохирол;
15. хохирлын хэмжээ нь даатгуулагчийн хариуцах хэсгээс бага бол;
16. бусад даатгалын гэрээ, байгууллага, хувь хүн, сангаас төлөгдөх хохирол.